МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ 2010/01

## Үнэ № 01(01)

## Үнэ

***Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ***

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2010 оны 1 дүгээр сард өмнөх сартай харьцуулахад 2.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 5.7 хувиар тус тус өссөн байна (Хүснэгт1).

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 2.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 4.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний үнэ 1.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Түүнчлэн согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 0.9 хувь, гэр ахуйн тавилга, барааных 0.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх 0.3 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 0.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 3.4 хувиар тус тус өсчээ. Харин эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 0.3 хувиар буурч, тээвэр, боловсрол, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ тогтвортой байв (Хүснэгт 1).

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын дүнгээр 2010 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүх бүлгийн үнэ дүнгээрээ 3.0-14.4 хувиар өсчээ.

**Хэрэглээний үнийн улсын индекс, бүлгийн дүнгээр, хувиар**

*Хүснэгт 1*

| Бараа, үйлчилгээний бүлэг | Жин, хувиар | 2010- I / 2009- I | 2010- I / 2009- XII |
|---|---|---|---|
| **Ерөнхий индекс** | ***100.0*** | ***105.7*** | ***102.3*** |
| Хүнсний бараа, ундаа, ус | 39.7 | 103.3 | 104.6 |
| Согтууруулах ундаа, тамхи | 2.8 | 112.3 | 100.2 |
| Хувцас, бөс бараа, гутал | 15.3 | 111.2 | 100.9 |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 10.8 | 103.0 | 101.6 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 5.6 | 108.9 | 100.4 |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 1.8 | 109.1 | 99.7 |
| Тээвэр | 9.0 | 103.3 | 100.0 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 2.9 | 105.1 | 100.3 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 3.1 | 103.7 | 100.1 |
| Боловсролын үйлчилгээ | 5.4 | 109.9 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 1.0 | 114.4 | 103.4 |
| Бусад бараа, үйлчилгээ | 2.7 | 112.1 | 100.0 |

ХҮУИ 2009 оны 1 сард өмнөх сарынхаас 0.8 хувиар өссөн бол 2010 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 2.3 хувь өсч 1.5 пунктээр нэмэгджээ (Зураг 1).

*Зураг 1*

**Хэрэглээний үнийн улсын индекс, 2008-2010 оны сараар**
**(өмнөх оны 12 сар =100)**




Утас: 322424, 326414, Факс: 976-51-261561
http://www.nso.mn
E-mail: information@nso.mn

© Зохиогчийн эрхийг хуулиар хамгаална.
Энэхүү мэдээллийг ашиглахдаа эх сурвалж нь Үндэсний Статистикийн Хороо болохыг дурьдана.

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ 2010/01

**Үнэ № 01(01)**

**Үнэ**

***Барилгын гол нэрийн материалын Улаанбаатар хот дахь үнэ***

Улаанбаатар хотод арилжаалагдаж байгаа эх орны үйлдвэрийн болон ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНСУ-д үйлдвэрлэсэн барилгын үндсэн 40 нэр төрлийн материалын үнийг 2010 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар мэдээнд хамрууллаа.

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2010 оны 1 дүгээр сард эх орны үйлдвэрийн улаан тоосгоны үнэ 20 хувь, хуурай палкных 7.1 хувиар тус тус буурч, цементнийх 22.6 хувь, захалсан банзных 53.3 хувиар тус тус өссөн байна. ОХУ-д үйлдвэрлэсэн шохойны үнэ 20.0 хувь, 100мм-ийн хадаасных 25.0 хувиар тус тус өссөн байна. БНХАУ-д үйлдвэрлэсэн ханын цаасны үнэ 15.4 хувь, паркетан шалных 17.6 хувь, шаазан суултуурынх 25.0 хувь, чулуугүй хар цаасных 30.0 хувь, шаазан угаагуурынх 31.0 хувь, тосон будагных 33.3 хувь, дүүжин таазных 35.7 хувь, 100мм-ийн хадаасных 38.9 хувь, өдрийн, суурьгүй гэрлийнх 50.0 хувь, шалны плитаных 60.0 хувиар тус тус өсч, бусад материалын үнэ өмнөх оны мөн үеийнхтэй ижил түвшинд байв. БНСУ-д үйлдвэрлэсэн ханын цаасны үнэ 4.7 хувиар өсчээ.

2010 оны 1 дүгээр сард өмнөх сарынхтай харьцуулахад ОХУ-д үйлдвэрлэсэн чулуутай хар цаасны үнэ 7.1 хувиар өсч, БНХАУ-д үйлдвэрлэсэн чулуугүй хар цаасны үнэ 4.4 хувиар буурч, харин шалны плитаны үнэ 6.7 хувиар, ханын хар цаасных 7.1 хувиар, паркетан шалных 11.1 хувиар, шаазан суултуурынх 15.4 хувиар, шаазан угаагуурынх 22.2 хувиар тус тус өссөн байна.

Утас: 322424, 326414, Факс: 976-51-261561
http://www.nso.mn
E-mail: information@nso.mn

© Зохиогчийн эрхийг хуулиар хамгаална.
Энэхүү мэдээллийг ашиглахдаа эх сурвалж нь Үндэсний Статистикийн Хороо болохыг дурьдана.

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ 2010/01

**Үнэ № 01(01)**
**Үнэ**

БАРИЛГЫН ГОЛ НЭРИЙН МАТЕРИАЛЫН УЛААНБААТАР ХОТЫН ДУНДАЖ ҮНЭ, үйлдвэрлэгч улс орноор

төг

| Материалын нэр, үйлдвэрлэгч улс орноор | Хэмжих нэгж | 2009 I | 2009 XII | 2010 I | 2010 I / 2009 I % | 2010 I / 2009 XII % |
|---|---|---|---|---|---|---|
| **Монгол улс** | | | | | | |
| Бетон зуурмаг М-200* | $м^3$ | - | 77 000 | 77 000 | - | 100.0 |
| Хөнгөн бетон 700* | $м^3$ | - | 83 000 | 83 000 | - | 100.0 |
| Улаан тоосго М-100 | мян.ш | 200 000 | 160 000 | 160 000 | 80.0 | 100.0 |
| Цемент М-500 | 50 кг | 4 730 | 5 800 | 5 800 | 122.6 | 100.0 |
| Вакуум цонх (15x15) | $м^2$ | 80 000 | 80 000 | 80 000 | 100.0 | 100.0 |
| Шалны банз (ховилгүй) | $м^3$ | 120 000 | 120 000 | 120 000 | 100.0 | 100.0 |
| Захалсан банз | $м^3$ | 15 000 | 23 000 | 23 000 | 153.3 | 100.0 |
| Палк (15x15), хуурай | ш | 14 000 | 13 000 | 13 000 | 92.9 | 100.0 |
| Эмульс (дотор)* | кг | - | 9 000 | 9 000 | - | 100.0 |
| Хөөсөнцөр (2.44x1.22м)* | $м^2$ | - | 15 000 | 15 000 | - | 100.0 |
| Замаск* | 25 кг | - | 4 500 | 4 500 | - | 100.0 |
| **ОХУ** | | | | | | |
| Хар цаас (чулуутай) 1x10м* | боодол | - | 14 000 | 15 000 | - | 107.1 |
| Хадаас 100мм | кг | 2 000 | 2 500 | 2 500 | 125.0 | 100.0 |
| Олиф | кг | 2 000 | 1 800 | 1 800 | - | 100.0 |
| Шохой (мель) | кг | 500 | 600 | 600 | 120.0 | 100.0 |
| **БНХАУ** | | | | | | |
| Цемент М-500 | 50 кг | 7 000 | 7 000 | 7 000 | 100.0 | 100.0 |
| Цонхны шил 5мм (нөлөөгүй) | $м^2$ | 12 000 | 12 000 | 12 000 | 100.0 | 100.0 |
| Цонхны шил 5мм (нөлөөтэй) | $м^2$ | 10 000 | 10 000 | 10 000 | 100.0 | 100.0 |
| Хар цаас (чулуугүй) 1x15 | боодол | 5 000 | 6 800 | 6 500 | 130.0 | 95.6 |
| Хадаас 100мм | кг | 1 800 | 2 500 | 2 500 | 138.9 | 100.0 |
| Тосон будаг | кг | 1 500 | 2 000 | 2 000 | 133.3 | 100.0 |
| Ханын цаас (10x0.53 м) | боодол | 6 500 | 7 000 | 7 500 | 115.4 | 107.1 |
| Эмульс (гадна)* | 18 кг | - | 18 000 | 18 000 | - | 100.0 |
| Эмульс (дотор)* | 18 кг | - | 6 500 | 6 500 | - | 100.0 |
| Шохой (мель) | кг | 300 | 500 | 500 | 166.7 | 100.0 |
| Плита 30x30 (шалны) | ш | 500 | 750 | 800 | 160.0 | 106.7 |
| Шаазан угаагуур | ш | 42 000 | 45 000 | 55 000 | 131.0 | 122.2 |
| Шаазан суултуур | ш | 60 000 | 65 000 | 75 000 | 125.0 | 115.4 |
| Өдрийн гэрэл (суурьгүй) | ш | 1 200 | 1 800 | 1 800 | 150.0 | 100.0 |
| Хаалга (төмөр) | ш | 130 000 | 130 000 | 130 000 | 100.0 | 100.0 |
| Крант* | ком | - | 25 000 | 25 000 | - | 100.0 |
| Уян шүршүүр | ш | 15 000 | 15 000 | 15 000 | 100.0 | 100.0 |
| Паркетан шал | $м^2$ | 8 500 | 9 000 | 10 000 | 117.6 | 111.1 |
| Дүүжин тааз | $м^2$ | 2 800 | 3 800 | 3 800 | 135.7 | 100.0 |
| Цавуу (тарган)* | кг | - | 4 000 | 4 000 | - | 100.0 |
| **ХБНГУ** | | | | | | |
| Эмульс (гадна)* | 18 кг | - | 60 000 | 60 000 | - | 100.0 |
| Эмульс (дотор)* | 18 кг | - | 47 000 | 47 000 | - | 100.0 |
| **БНСУ** | | | | | | |
| Ханын цаас 12x0.5 | боодол | 4 300 | 4 500 | 4 500 | 104.7 | 100.0 |

Тайлбар: * - Бүтээгдэхүүний тодорхойлолт 2009 оны 8-р сараас эхлэн өөрчлөгдсөн болно.

Утас: 322424, 326414, Факс: 976-51-261561
http://www.nso.mn
E-mail: information@nso.mn

© Зохиогчийн эрхийг хуулиар хамгаална.
Энэхүү мэдээллийг ашиглахдаа эх сурвалж нь Үндэсний Статистикийн Хороо болохыг дурьдана.